

ҮАГ

**ҮАГ-ын 2004 оны бүтээгдэхүүн, ажил,
үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
байгаль орчны аудит**

2004 оны 11 дүгээр сар

**Тусгай хамгаалалттай
газар нутгаа тусгайлан
хамгаалж чадахгүй
байна**

**Тусгай хамгаалалттай газар
нутгийн сүлжээ, түүний
удирдлагын үр нөлөө**

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	1
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	2
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	2
Аудитын дүн	ТХГН-ийн байгаль орчны хамгаалалт	3
	ТХГН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт	13
Дүгнэлт		17
Холбогдох байгууллагын санал	Байгаль орчны яамны санал	18
Зөвлөмж		19
Хавсралт	Аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт	20

Агуулга

Тайланд гарах товчилсон үгс

ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ДЦГ	Дархан цаазат газар
БЦГ	Байгалийн цогцолборт газар
БНГ	Байгалийн нөөц газар
ДГ	Дурсгалт газар
ДХБШМ	Дэлхийн хүн ба шим мандал
БОЯ	Байгаль орчны яам
АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ХЦУГ	Хилийн цэргийн удирдах газар

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

ҮАГ-ын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн сүлжээ, түүний удирдлага, үр нөлөөнд байгаль орчны аудит хийлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, түүний удирдлагын үр нөлөөтэй холбоотой дараахь асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах, үр нөлөөг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд:

- ❖ ТХГН-ийн байгаль орчны хамгаалалт
- ❖ ТХГН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Аудитад Байгаль орчны яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын хэлтэс, түүний харъяа хамгаалалтын 15 захиргаад болон холбогдох бусад мэргэжлийн байгууллага хамрагдав.

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн шалгалтын журамд тусгагдсаны дагуу ажлын төлөвлөгөө, тайлан, орон нутагт томилолтоор ажилласан хэсгийн тайланг унших, судалгаа мэдээг шинжлэх, газар дээр нь биечлэн очиж үзэх, зураг авч баримтжуулах, боловсон хүчний анкеттай танилцаж нэгдсэн судалгаа гаргах, санхүүгийн тайланд дүн шинжилгээ, ажиглалт, судалгаа хийх зэрэг арга зүйг ашиглалаа.

Түүнчлэн БОЯ-ны ТХГН-ийн удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд, ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын удирдлага, байгаль хамгаалагчид, орон нутгийн оршин суугч, иргэдээс ярилцлага, тодруулга авч, ТХГН түүний орчны бүсийг тойрч үзэн, байгаль хамгаалагчдын ажилтай танилцсаны зэрэгцээ Дэлхийн байгаль хамгаалах сан, байгаль хамгаалах зорилго бүхий Төрийн бус байгууллагуудын ажилтнууд, Байгаль, ой, усны нөөцийн газрын мэргэжилтнүүдтэй уулзаж, мэргэжлийн зөвлөгөө авч ажиллав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийн заалтыг аудитын шалгуур болгон ашиглав. Үүнд:

- ❖ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн
 - 9.2 дахь заалт “Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр

Ерөнхий зүйл

- судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”
 - 11 дүгээр зүйл “Хязгаарлалтын бүсийн дэглэм”
 - 12 дугаар зүйл “Дархан цаазат газарт” хориглох үйл ажиллагаа
 - Байгалийн цогцолборт газрын бүсийн дэглэмийн тухай 15, 16, 17, 18 дугаар зүйл
 - Байгалийн нөөц газрын дэглэмийн тухай 21 дүгээр зүйл
 - Дурсгалт газрын дэглэмийн тухай” 24 дүгээр зүйл
 - Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны тухай 30 дугаар зүйл
- ❖ ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн:
- 3.3 дахь заалт “Орчны бүс нь дархан цаазат газрын хилийн заагийн гадна байх бөгөөд байгалийн цогцолбор газрын хувьд түүний хилийн заагийн гадна буюу хязгаарлалтын бүстэй нь давхцсан байж болно.”
 - 5.3 дахь заалт “Судалгааны бүх мэдээллийг 1:500000-аас багагүй масштабтай газрын зурагт буулгаж түүндээ газар, ус, ан амьтан, ой ургамлын нөөцийг тусгана.”

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Байгаль орчны энэхүү аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Байгаль орчны аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн болон зарим аймгийн аудитор, шинжээч нар 2004 оны 9 дүгээр сарын 14-нөөс 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.


Аудитын дүн

ТХГН-ийн байгаль орчны хамгаалалт

Дэлхийн эдийн засгийн хөгжил, хүн амын хэт өсөлт, агаар мандлын дээд давхрага дахь озоны цоорхой, хүлэмжийн хийн ялгаруулалт, хүчиллэг бороо, уур амьсгалын дулаарал, ган цөлжилт, биологийн төрөл зүйлийн хомсдол зэргээс экологийн хямрал гүнзгийрч, үүний улмаас сүүлийн 400 орчим жилийн дотор 400 гаруй амьтан устан үгүй болж, 600-аад зүйлийн амьтны тоо толгой асар ихээр цөөрсөн, ашигт малтмалын хэрэглээнээс байгаль орчин ихээхэн бохирдож байна гэж Дэлхийн байгаль хамгаалах сан дүгнэжээ.

Монгол орны байгаль орчинд экологийн дээрх өөрчлөлтүүд ажиглагдаж байгаа бөгөөд байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалах, биологийн төрөл зүйлийг хамгаалах нэг чухал арга хэмжээ бол газар нутгийг тусгай хамгаалалтад авах явдал юм.

2004 оны 1 дүгээр сарын байдлаар Монгол Улсын газар нутгийн 13.39 хувь буюу 20,9 сая га талбай бүхий 54 газрыг улсын тусгай хамгаалалтад авчээ.



2030 он гэхэд улсын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг тусгай хамгаалалтад авч, ТХГН-ийн зохистой харьцааг бүрдүүлэх зорилт тавьж, 1998 онд УИХ-аар баталсан “ТХГН-ийн үндэсний хөтөлбөр”-т заасны дагуу 1998 оноос 2004 оны хооронд 2,2 сая га талбай бүхий 11 газрыг байгалийн цогцолборт газраар, 0,1 сая га талбай бүхий 4 газрыг байгалийн нөөц газраар тус тус хамгаалалтад авч, ТХГН-ийн сүлжээг өргөтгөсөн байна.

2005 он гэхэд тусгай хамгаалалтад авбал зохих 6455,1 мянган га талбай бүхий 16 газрыг сүлжээнд хамруулах

Аудитын дүн

үндэслэл, саналыг БОЯ-наас боловсруулж Засгийн газарт өргөн барьсан боловч ашигт малтмалын орд газрын илэрцтэй зарим хэсэг нь давхацсан, ашигт малтмалын лиценз олгогдсон, саналын үндэслэл боловсрогдож байгаа зэрэг шалтгааны улмаас хойшлогдож, сүлжээг өргөтгөх төлөвлөгөө бүрэн хэрэгжсэнгүй.


Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн байгалийн бүс, бүслүүрийн төлөөллийг авч үзвэл:

№	Байгалийн бүс, бүслүүр	ТХГН-ийн тухайн бүс бүслүүрт эзлэх хувь	ТХГН-ийн нийт талбайд эзлэх хувь
1	Өндөр уулын	14,0	12,7
2	Ойт хээрийн	6,5	12,5
3	Тал хээрийн	6,4	10,0
4	Цөлөрхөг хээрийн	18,6	26,5
5	Цөлийн	23,5	38,5
	Улсын нийт нутаг дэвсгэрт	13,4	100,0

Байгалийн бүс, бүслүүрийн төлөөлөл ТХГН-ийн сүлжээнд үндсэндээ хамрагдсан боловч ойт хээрийн болон тал хээрийн бүсийн төлөөлөл харьцангуй бага байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийг “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуульд заасан дөрвөн ангиллаар авч үзвэл 10,4 сая га талбайг дархан цаазтай газар, 8,4 сая га талбайг байгалийн цогцолборт газар, 1,9 сая га талбайг байгалийн нөөц газар, 0,07 сая га талбайг дурсгалт газар тус тус эзэлж байна.

ТХГН-ийн ангилал



ТХГН-ийн хамгаалалтын захиргаадад хийсэн аудитын дүнгээс үзэхэд ТХГН-ийн орчны бүсийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг харгалзан ДЦГ болон БЦГ-ын орчны

Аудитын дүн

бүсийг зөв зүйтэй тогтоосон байна. Харин Дорнод хамгаалалтын захиргаанд хамгаалагдаж байгаа ТХГН-ийн газар, ус, ан амьтан, ой ургамлын нөөц байршлыг тусгасан 1:500000-аас доошгүй масштабтай газрын зураг хийгдээгүй байна.

ДЦГ, БЦГ-ын хязгаарлалтын бүсийн тэмдэгжүүлэлт хангалтгүй байгаагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ТХГН-ийн орчны болон хязгаарлалтын бүсэд нэвтрэн орж хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж байна.

❖ ТХГН-т хуулиар хориглосон уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй ноцтой зөрчлүүд илэрлээ.

Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн хязгаарлалтын бүс буюу Сүүж уулын орчимд 2004 оны 1 дүгээр сараас Ч.Чинбат эзэнтэй “Монзол” ХХК хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа эхэлж, улмаар 250 гаруй машин, 1000 орчим хувь хүн цугларч, хоногт 5-8 удаа тэсэлгээ хийн, алттай чулуу, шороог машинаар ачин 5 цооног үүсгэжээ.

БОЯ дээрх газарт АМХЭГ-ын итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага “Оюу Сүрвэв” ХХК-иар хохирлын хэмжээг үнэлүүлэхэд 175-340 кг алт олборлосон, 335 га талбай эвдэрч бохирдон талхлагдсан байна гэсэн дүгнэлт гарчээ.

2002 оноос Говьгурван сайхны БЦГ-ын баруун хэсэг Гурван тэс сумын нутаг дэвсгэр дэх Тамгат, Дэвтээр, Дэвсэг Хүрэн овоо, Сэврэй сумын нутаг дэвсгэр, Алаг өндөр зэрэг газарт гар аргаар алт олборлож их хэмжээний газар ухсанаас Тамгатад ойролцоогоор 10 га, Хүрэн овоонд 5 га, Дэвсэгтэд 0,2 га, Алаг өндөрт 0,5 га, Дэвтээрт 8,0 га газар эвдэрсний дээр автомашин техникээ нуух, зугатаах, газар дөтлөх, нуугдаж явах зэрэг шалтгаанаас олон тооны зам үүсжээ.

ТХГН-ийн тухай хуулиар БЦГ-ын хилийн цэсийг УИХ-аар батлах болсонтой холбогдуулан УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор Говь гурван сайхны байгалийн цогцолборт газар (ГБЦГ)-ын хилийн цэсийг дахин батлахдаа ГБЦГ-ын нутаг дэвсгэрт хамрагдсан, экосистемийн хувьд онцлог үүрэг бүхий Алтан уулыг алтны уурхайн зориулалтаар ашиглах аймгийн удирдлагын саналын дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн дэвсгэрээс гаргаснаас алт олборлож Алтан уулын Тамгатад 325 куб.м бүхий 150 ширхэг нүх, алт угааж овоолсон 90 куб.м шавар овоо үүсчээ.

ДЦГ, БЦГ, БНГ-т ашигт малтмал олборлох нь ТХГН-ийн тухай

Аудитын дүн

хуулиар хориглосон үйл ажиллагаа бөгөөд үүний улмаас хөрсний эвдрэл үүсэн цөлжилт хурдасч, ан амьтан дайжин, экологийн тэнцвэр алдагдаж байна.

❖ ТХГН-т явагдаж буй аялал жуулчлалын үйл ажиллагаа экологийн систем, биологийн төрөл зүйлийн тэнцвэрт байдалд нөлөөлж байна.

ТХГН-т байгалийн өвөрмөц тогтолцоо, унаган төрх, амьтан ургамал, түүхийн дурсгалыг түшиглэн байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ унаган төрхийг хадгалах, экологийн даацыг зохистой байлгаж, орчныг бохирдуулахгүй байх бодлого барьдаг олон улсын жишиг бий.

Гэтэл Монгол Улсын хэмжээнд, тэр тусмаа ТХГН-т байгалийн аялал жуулчлал хөгжүүлэхдээ байгаль орчныг хамгаалах нэгдсэн бодлого алга байгаагаас дараахь сөрөг үр дагавар гарч байна.

БОЯ, холбогдох бусад байгууллагуудаас ТХГН-ууд ялангуяа, Богдхан уулын ДЦГ-ын Зайсан, Нүхт, Жаргалантын ам, Горхи тэрэлж, Хөвсгөлийн БЦГ-уудад экологийн даацын нэгдсэн үнэлгээ хийгээгүй, газар ашиглалтыг нарийвчлан тусгасан газар зохион байгуулалтын төлөвлөгөө гаргаагүйгээс хэсэг газарт аялал жуулчлалын бааз, амралт сувиллын газрууд хэт төвлөрч, түүнийг дагаж, ашиглалтын бусад хэлбэрүүд нэмэгдэж байна. Энэ нь ТХГН-ын экологийн даац алдагдахад хүргэж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Горхи тэрэлжийн БЦГ-ын даацын үнэлгээг 1999 онд хийсэн гэх боловч тодорхой материал алга байна.

Аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгжийн стандартын шаардлагын хэмжээнд тохижуулаагүй ахуйн бохир усны цооног, хөрсөнд шууд шингээж байгаа бохир ус, хамгаалах талбайд байгууллагуудын ил задгай хаясан хатуу хог хаягдал, авто машины салаа зам зэргээс хөрс талхлагдан эвдэрч, ургамлын бүтэц алдагдан, орчны хөрсийг их хэмжээгээр бохирдуулж байна. Жишээ нь: Хөвсгөлийн БЦГ-ын жуулчны баазуудын бохирын хоолой, шугам Хөвсгөл нуурын захаас 300 м зайтай байх ёстой атал “Хан тайга”, Хилийн цэргийн жуулчны баазууд 14 метрийн зайд байрлаж байна.

Мөн Хөгнө-Тарны БЦГ-ын аудитад хамрагдсан жуулчны баазуудын 66,6 хувийх нь бохирын цооногууд дүүрсэн, бохироо тухай бүр татуулж цэвэрлэх талаар хангалтгүй

Аудитын дүн

ажиллаж байлаа.

Богдхан уулын ДЦГ-ын Зайсангийн ам хязгаарлалтын бүсэд хамаарагддаг боловч 100 гаруй айл амьдарч байгаа нь ердийн эдэлбэр газраас ялгагдахгүй болжээ. Тус газрын хамгаалалтын захиргаанаас зөвшөөрөлгүй буусан байгууллага, айл өрхийг шүүхэд өгч, тэдгээрээс 45 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх шүүхийн шийдвэр гарсан боловч дөнгөж 1 айл нүүж, бусад нь өнөөг хүртэл шийдвэр биелүүлсэнгүй.

1999 онд хийсэн судалгаагаар Өвөр Горхид 82 өрхийн 400 хүн, нийт 8618 толгой мал зусаж байсан бөгөөд хамгаалалтын захиргаанаас нийт 30 гаруй өрхийг нүүлгэж, 60 айлд нүүх мэдэгдэл өгсөн боловч үр дүн гарсангүй.

Энэ нь ТХГН-т газар ашиглах гэрчилгээг ТХГН-ийн удирдлагын хэлтэс замбараагүй олгосон, ТХГН-ийн хамгаалалтын захиргаад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд хяналт тавиагүй, хууль зөрчсөн аж ахуйн нэгжийг газар эзэмших гэрчилгээг хураах арга хэмжээг авч чадаагүйтэй холбоотой байна.

БОЯ 2003-2004 онд Богдхан уулын ДЦГ-т зочид буудал, аялал жуулчлалын болон амралт үйлчилгээний 3-7 давхар барилга бариулах газар ашиглах гэрчилгээг ИНЕГ-ын харьяа ОУНБ “Жи Ди Энд Би” ХХК, “Сарнайх” ХХК, “Мапекс” ХХК, “Жнэп” ХХК-иудад олгосон нь ТХГН-ийн тухай хуулийн 12-ын 5-дахь заалтыг зөрчжээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий зарим компани орлого хөөцөлдөж, үнэлгээг бодитой хийгээгүйгээс ДЦГ-т барилга байгууламж барих боломжтой мэтээр үнэлгээ хийж, БОЯ түүнийг нь баталсан байна.

Богдхан уулын ДЦГ-т нийт 63 аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 8 аж ахуйн нэгж гэрчилгээгүй, 2 нь ТХГН-т газар ашиглах гурвалсан гэрээгүй, 5 байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгээгүй, 9 байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй байлаа.

Горхи тэрэлжийн БЦГ-т байрлаж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны баазын 8.4 хувь буюу 6 аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй байна.

Хангайн нурууны БЦГ-ын аялал жуулчлалын 4 байгууллагын

Аудитын дүн

газар ашиглах гэрээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх материал, баримтууд хамгаалалтын захиргаа болон сумдын ЗДТГ-т алга байсан бөгөөд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан гэж үзэж болохоор байна.

Мөн Тариат суманд н.Сүрэнжав гэгч хүн жуулчны баазын барилга ямар ч зөвшөөрөлгүй барьж эхэлжээ.

ТХГН-т үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллага гэрээгээ сунгаагүй байна.

Тухайлбал, ТЗҮААЭГ-ын “Горхи” амралтын газар ашиглах зөвшөөрлийн хугацаа дууссан, Зөгий үржүүлгийн газар, ТИС-ийн оюутны “Полигон”, “НИК ТУР”, “Гацуурт”, “Гурван түргэн” зэрэг байгууллагууд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй үйл ажиллагаа явуулж байна.

“НИК” ХК-ний НИК ТУР амралтын газар, “Тэрэлж” ХХК, “Баялаг орд” ХХК, “Оранже” ХХК, “Гурван түргэн” ХХК, “Мөнххайлан” ХХК, “Баянхадат тур” ХХК гэх мэт газрууд газар ашиглах гэрээ, гэрчилгээгээ БОЯ-аар шинэчлүүлээгүй байлаа.

Болор зуслангийн дэргэд орших Монтулга ХХК БОЯ-аас газар ашиглах шийдвэр гараагүй байхад гэр, байшин барьж амралтын үйл ажиллагаа эрхэлсэн, Горхийн баруун салаанд “Жуулчлал” ХЭАА-н нэр дээр үйл ажиллагаа явуулж байсан аялал жуулчлалын бааз хэнд шилжсэн нь мэдэгдэхгүй, холбогдох бичиг баримтаа шинэчлүүлсэн эсэх нь тодорхойгүй үйл ажиллагаа явуулж байна.

Богдхан уулын ДЦГ-т ТХГН-ийн тухай хуульд заасан газар ашиглах гэрээг огт байгуулаагүй 27 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 48 хувь нь төрийн байгууллагууд байна. Үүнд Зайсангийн аман дахь Ерөнхий боловсролын 32 дугаар сургууль, хүүхдийн 35-р цэцэрлэг, ШШГЕГ-ын 411-р анги, ШШГЕГ-ын 401 анги, Дүнжингарав зочид буудал, Чулуутын аман дахь Хүүхдийн урлан бүтээх төвийн хүүхдийн зуслан, Их тэнгэрийн аман дахь төрийн үйлчилгээний “Их тэнгэр цогцолбор”, Түргэний ам дахь ХЦУГ-ын харъяа “Өсвөрийн ойчид” зуслан зэрэг байгууллагыг дурдаж болно.

Хөвсгөлийн БЦГ-т 27 аж ахуйн нэгж аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаагаас заримынх нь газар ашиглалтын гэрээний 5 жилийн хугацаа дууссан, сунгалт хийгдээгүй байна.

Аудитын дүн

Үүнээс үзэхэд аялал жуулчлалыг байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр хөгжүүлэх, газар ашиглалтын даацыг тооцох, байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тулгуурлан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал хангалтгүй байна.

❖ ТХГН дахь биологийн төрөл зүйлийн өсөлт, бууралтад хяналт, шинжилгээ, зохицуулалт хангалтгүй хийгдэж байна.

ТХГН-ийн удирдлагын хэлтэст төрөл зүйлийн өсөлт, бууралтад хийсэн нэгдсэн судалгаа, шинжилгээ, түүнд тавьсан хяналт, зохицуулалтын материал байсангүй. Харин олон улсын төслийн шугамаар хэд хэдэн ТХГН-ийн судалгаа хийгдсэн боловч хамгаалалтын захиргаад түүнийг үр дүнтэй ашиглаж чадахгүй байна.

Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутагт дахь биологийн төрөл зүйлийн өсөлт бууралтад хяналт, шинжилгээ, зохицуулалтын талаарх судалгаа шинжилгээг 1999 оноос хойш 13 удаа хийсэн ч үйл ажиллагаандаа ашиглаагүй байна.

❖ Хулгайн ан, байгалийн баялгийг зүй бусаар ашиглах явдалтай хийх тэмцэл хангалтгүй байна.

Монгол орны ой бол сэрүүн бүсийн ойн өмнөд хязгаар, дэлхийн усны гурван том ай савын хагалбарыг дагаж ургасан, нутаг дэвсгэрийн дөнгөж 8,1 хувийг эзэлдэг. 1974, 2002 онд хийсэн судалгааг харьцуулан үзвэл 28 жилийн хугацаанд улсын хэмжээнд байгалийн ой 1187,6 мянган гагаар хорогджээ.

ТХГН-ийн 30 орчим хувь нь ой бүхий газар бөгөөд улсын нийт ойн сан бүхий газар нутгийн 18 орчим хувь тусгай хамгаалалтад хамрагджээ.

2003 онд улсын хэмжээнд ТХГН-т ойн 3066 зөрчил илрүүлж 3009-г барагдуулжээ. Энэ нь байгаль хамгаалах улсын байцаагчдын илрүүлсэн зөрчлийн 78,8 хувийг эзэлж байгаа ч зөрчлийг таслан зогсоож чадахгүй байна.

Сүхбаатар аймгийн Дашбалбар сумын ЗДТГ-ын удирдлагууд БНГ-аас албан ёсны зөвшөөрөлгүйгээр өвлийн түлшний хэрэгцээнд ойролцоогоор 200 шоо метр түлээ бэлтгэжээ.

Хан Хэнтийн дархан цаазат газрын орчны бүс нутаг Батширээт, Өмнөдэлгэр сумын нутагт шатсан их хэмжээний

Аудитын дүн

ойг цэвэрлэх арга хэмжээг сумын засаг захиргаа болон хамгаалалтын захиргаанаас хамтран аваагүй байлаа. Энэ нь аянга бууж дахин түймэр гарах нөхцлийг бүрдүүлдэг байна.

Хар ус нуурын БЦГ-ын бургасыг сийрэгжүүлэх цэвэрлэгээг 5 жил тутамд хийх ёстой атал түлшинд ашиглах зөвшөөрлийг тухайн сумын байгаль орчны байцаагч жил бүр олгосноос голын сав дагуу бургас, харганы ургац муудан хорогдож, байгалийн унаган төрхийг алдагдуулах, цөлжилт элсний нүүдлийг ихэсгэх сөрөг үр дагаврыг бий болгожээ.

Тужийн нарсны БЦГ-т 1993 онд ой зохион байгуулалт хийсэн бөгөөд сүүлийн 10 гаруй жилд хүний нөлөөгөөр ихээхэн өөрчлөгдсөн ч мэргэжлийн байгууллагын судалгаа, дүгнэлт бодитой гараагүй байна. “Ойн тухай хууль”-иар ой зохион байгуулалтыг 10 жил тутам хийж байхаар заасны дагуу ой зохион байгуулалт хийх хэрэгтэй байна.

ШУА-ийн дэргэдэх Биологийн хүрээлэнгээс авсан мэдээгээр Монгол орны хэмжээнд 1986 онд ан амьтны нэгдсэн тооллого явуулснаас хойш нэгдсэн тооллого хийгдээгүй бөгөөд ан амьтныг хэсэгчлэн тоолж иржээ. 2003-2004 онд тоолсон улаан номонд орсон зарим амьтдын тоо толгойг 1986 оны тооллогын дүнтэй харьцуулбал:

	(тоо толгойгоор)	
	1986 онд	2003-2004 онд
Аргаль	60000	15000
Хулан	25000	20000
Ирвэс	3000	700-1200

Үүнд зөвхөн халиун бугын тоо толгойг авч үзвэл:



1986 онд улсын хэмжээнд 130,0 мянган халиун буга байжээ.




2003 онд улсын хэмжээнд 8,0-9,0 мянган тоо толгой байна. Энэ нь 1986 оноос 16,3-14,4 дахин буурчээ.

ТХГН-ийн хэмжээнд ан амьтны нэгдсэн судалгаа байхгүй

Аудитын дүн

бөгөөд Богдхан уулын ДЦГ-т 1990-ээд оны эхэнд 3,0 мянга гаруй бугатай байсан бол 2003 оны өвөл 40 дахин хорогдож, 70 гаруй толгой буга байгааг судлаачид тогтоожээ. Богдхан уулын ДЦГ-ын бугын тоо толгойн хэлбэлзлийг авч үзвэл:



Буга, согооны хүйсийн биологийн зохистой харьцаа 1 бугад 6-8 согоо байдаг бол Богдхан уулын ДЦГ дахь бугыг авч үзвэл 46,5% буга, 53,8% согоо буюу харьцаа 1:1 байгаа нь харьцаа алдагдсаныг үзүүлж байна.

Бугын тоо толгой цөөрөх гол шалтгаан нь бугын ясан болон цусан эвэр, эр бугын чив засаа, эм бугын сүүл, хээлтэй сав зэргийг хил гарган худалдах зорилгоор хулгайн ан ихээр хийсэн, үргэж дайжсан зэргээс шалтгаалжээ. Ан агнуурын хууль тогтоомж зөрчиж хууль бусаар буга, согоо агнасан гэмт хэрэг 1998-2003 онд улсын хэмжээнд 172 бүртгэгдсэн байна. Гэтэл зөвхөн Богдхан уулын ДЦГ-ын буга сүүлийн 5 жилд 400 гаруй толгойгоор буурсан нь хулгайн ангийн зөрчлийг бүрэн илрүүлж чадахгүй байгааг харуулж байна.

2004 онд БОЯ Хустайн нурууны БЦГ-ын орчны бүсээс сэргээн нутагшуулах зорилгоор буга, согоог Богдхан ууланд шилжүүлэн нутагшуулжээ.

Сүүлийн жилүүдэд ажиглагдахуйц ховордож байгаа тарвага 1986 онд 12982,0 мянга орчим толгой тоологдож байжээ. Монгол тарваганы арьсны үнэ тогтмол өсөж 2004 оны 10 дугаар сарын байдлаар 10,0 мянган төгрөгт хүрсэн нь тарвагыг хууль бусаар агнах нэг үндсэн шалтгаан болж байна.

Аудитын дүн

Дархан цаазат Богдхан уулын тарваганы тоо толгой 1997 онтой харьцуулан үзэхэд 6-8 дахин буурчээ. Энэ нь хулгайн ан, нөгөө талаас нийслэл хоттой ойрхон оршдог учир сийрэгжүүлэлт тодорхой хэмжээгээр хийж байдагтай холбоотой юм.

Дорнод ТХГН-ийн хамгаалалтын захиргаанаас Монгол Дагуурын ДЦГ-ын А хэсгийн онгон бүс болох Хөх уул орчимд хулгайгаар тарвага агнах явдлыг зогсоох зорилгоор хяналт тавьж, хууль зөрчигсдийг торгох, буу хэрэгслийг хураах арга хэмжээ авсан боловч олигтой үр дүнд хүрээгүй байна.

Онон Балжийн БЦГ нутагт тарвага цөөрсөн тул агналт хийхийг хориглосон шийдвэрийг орон нутгийн ИТХ-аар гаргуулсан байна. Угтамын БНГ-ын орчны иргэдтэй уулзахад буга, зэрлэг гахайн тоо цөөрсөн болохыг мэдээлж байв.

Хөвсгөлийн хамгаалалтын захиргаа байгууллагын хөрөнгөөр далайн эрэг орчмын уулуудаар мөрөөр болон хэсэгчлэн тоолох аргаар хэрэмний тооллого явуулахад 1000 га-д 2 толгой хэрэм ногдож байгаа нь хэрэм устах аюулд орсныг харуулж байна.

Хорго Тэрхийн БЦГ-ын Тэрхийн цагаан нуураас аймгийн Засаг Даргын шийдвэрээр 2002 онд Эрд хул ХХК 2,0 тн, 2003 онд Шарнуур трейд ХХК 3,0 тн загас тус тус агнасан нь ТХГН-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчжээ.

ТХГН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

ТХГН-ийн тухай хуулинд зааснаар БОЯ ТХГН-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг ТХГН-ийн удирдлагын хэлтэс, харьяа 16 хамгаалалтын захиргаагаар дамжуулан хэрэгжүүлж иржээ.

БОЯ-ны ТХГН-ийн удирдлагын хэлтэс дарга, 4 мэргэжилтний орон тоотой ажиллаж байжээ. Говийн бага ДЦГ-ын Б хэсэгт хууль бус алт олборлогчдын үйл ажиллагааг урьдчилан сэргийлж, таслан зогсоож чадаагүй гэсэн үндэслэлээр ТХГН-ийн удирдлагын хэлтсийн дарга, 3 мэргэжилтнийг 2004 оны 3 дугаар сард үүрэгт ажлаас нь чөлөөлжээ. Гэсэн ч тус хэлтсийн дарга өнөөг хүртэл томилогдоогүй, туршлагатай, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлээгүйгээс тус хэлтсийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байна.

БОЯ-ны ТХГН-ийн удирдлагын хэлтэс ба Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны газрын хоорондын ажлын уялдаа муугаас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль

Аудитын дүн

орчныг хамгаалах төлөвлөгөөтэй хэдэн компани ТХГН-т үйл ажиллагаа явуулж байгааг тогтоох боломжгүй байна.

БОЯ-наас Хустайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны үүргийг “Хустайн цогцолборт газар” төрийн бус байгууллагад гэрээгээр шилжүүлсэн боловч тушаалаа одоо болтол гаргаагүйгээс тус захиргаа нь төрийн бус байгууллагын хэвлэмэл хуудас, тамга тэмдэг ашиглан үйл ажиллагаагаа явуулж иржээ. Энэ нь тус цогцолбор газрын улсын байцаагчийн эрх бүхий ажилтны шүүх, хяналтын байгууллагад гаргасан нэхэмжлэл, илрүүлсэн хэрэг, зөрчлийг шийдвэрлэх явцад цаг хугацаа алдах, хэрэг буцахад хүргэдэг байна.

УИХ-аас баталсан ТХГН-ийн үндэсний хөтөлбөрийн эхний үе шатны хэрэгжилтийг урьдчилсан байдлаар авч үзвэл 3 заалт бүрэн хэрэгжиж, 2 заалт үр дүн гарах шатандаа, 2 заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Хамгаалалтын захиргааны төсөв хүрэлцээ муутай, ажлын цар хүрээ, тооцоо, судалгаа, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангах шаардлагыг харгалзалгүй үндэслэл муутай батлагддагаас хөрөнгө мөнгөний эх үүсвэр дутагдаж иржээ. Жишээ болгон 2003 оны зарим зардлын төсвийг үзүүлбэл:

(мянган төгрөг)

Зардлын зүйл	Нийт төсөв	Нэг хамгаалалтын захиргаанд оногдох дундаж
Тээвэр, шатахуун	2200,0	146,6
Гэрэл цахилгаан	1618,0	107,8
Зөөлөн эдлэл, нормын хувцасны зардал	550,0	36,6
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	0,0	0,0

Үүнээс үзэхэд хулгайн ан, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулахад хөрөнгө төсөвлөгдөөгүй байна.

2003 онд ТХГН-ийн хамгаалалтын захиргаанд 400,2 сая төгрөг зарцуулсан нь нэг захиргаанд дунджаар 27,9 сая төгрөг оногдож байна. Нийт зардлын 48,1 орчим хувийг цалин хөлсөнд, 12,0 хувийг НДШ-д, 8,3 хувийг шатахуунд, 5 хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаатай холбоотой зардалд, үлдэх хэсгийг бусад зардалд тус тус зарцуулжээ.

Аудитын дүн

Төсвийг гүйцэтгэлтэй нь харьцуулахад хууль бус үйл ажиллагааг зогсоох гэж хөрөнгө зарснаас бүх хамгаалалтын захиргаадын төсөв хэтрэлттэй гарчээ.

Хамгаалалтын захиргаадын орон тоог цомхотгож байгаагаас хүрэлцээ муудаж, ажлын чанар, үр дүн багасчээ.

Өмнөдговийн УТХГ-уудын хамгаалалтын захиргааны хувьд газар нутгийн хэмжээ, хэрэгжүүлэх ажлын цар хүрээ зэргийг харгалзан 8 мэргэжилтэнтэй байхаар менежментийн төлөвлөгөөнд тусгасан боловч 2001 онд 5 мэргэжилтэнтэй ажиллаж байсан орон тоог цомхотгож одоо 3 мэргэжилтэнтэй ажиллаж байна.

Дорнод УТХГ-ын хамгаалалтын захиргаанд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Ганга нуурын байгалийн дурсгалт газрын хамгаалалтыг хариуцуулсан боловч тусгай хамгаалалтын асуудлыг албан ёсоор хариуцуулаагүй, байгаль хамгаалагчийн орон тоог баталж өгөөгүй байна.

БОЯ, “Хустайн цогцолборт газар” ТББ-ын хооронд байгуулсан хамгаалалтын захиргааны үүргийг гүйцэтгүүлэх гэрээгээр захиргааны үйл ажиллагаанд зориулан жил бүр 7000 ам.доллартай тэнцэх санхүүжилтийг улсын төсвөөс өгнө гэж заасан ч 2004 оны 10 дугаар сарын байдлаар санхүүжилт олгоогүй байна.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаад өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломж байгаа боловч санаачлага гаргахгүй байна. Жишээ нь: Хан хэнтийн хамгаалалтын захиргаа 2002, 2003 он, 2004 оны эхний 3 улирлын байдлаар газрын төлбөрийн орлогын 30 хувь буюу 18.2 сая төгрөг төвлөрүүлж авах ёстой боловч 2004 онд 540.0 мянган төгрөг авч өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алджээ.

Дээрх байдал Богдхан уулын ДЦГ-т давтагдаж, 2003 онд нийт 52 аж ахуйн нэгж 15,4 сая төгрөгийн газрын төлбөр төлөхөөс зөвхөн 16,2% нь төлөгдөж, үлдэх 12,9 сая төгрөгийг төвлөрүүлж чадаагүй байна.

Хөгнө-Тарны БЦГ-ын хамгаалалтын захиргаа Байгаль орчны сайдын 2001 оны 117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “ТХГН-т үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх журам”-ын 1-ийн 2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2004 онд зөвхөн аудитад хамрагдсан 6 аялал жуулчлалын баазаас 19,8 орчим сая төгрөг олох боломжийг алджээ.

Аудитын дүн

Олсон орлогын хэмжээгээр дараа жилийн санхүүжилтийг бууруулж тооцдог явдал хамгаалалтын захиргаадыг орлогоо нэмэгдүүлэх сонирхолгүй болоход нөлөөлдөг байж болох юм.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаадад нийт 348 хүн ажиллаж байгаагийн 214 нь байгаль хамгаалагч байна. Үүнийг Засгийн газрын 1997 оны 41 дүгээр тогтоолоор баталсан нэг байгаль хамгаалагч өндөр ууланд 60,0-80,0, ойт хээрийн бүсэд 40,0-60,0, хээрийн бүсэд 80,0-100,0, цөлийн бүсэд 150,0-300,0 мянган га хариуцан ажиллах талбайн нормативтай харьцуулан үзэхэд 60 – 134 орчим хүнээр дутуу ажиллаж байна.

Увс нуурын ай савын ТХГН-ийн хамгаалалтын захиргааны нэг байгаль хамгаалагч 110,0 мянган га газар хариуцаж байгаа нь нормативт хэмжээнээс бараг 3 дахин их, Хан хэнтийн ТХГН-ийн нэг хамгаалагчид 90,0-435,0 мянган га орчим газар ногдож байгаа нь нормативаас 6 дахин их байна.

Хамгаалалтын 15 захиргаа болон мэргэжилтнүүд хамгаалах хэрэгсэл, уналганы мориор стандартын дагуу бүрэн хангагдаагүй байна.

Байгаль хамгаалагчдын цалинг ТҮ-4-өөр тооцож олгодог ба дундаж цалин 50,0 орчим мянган төгрөг, цалингийн бусад нэмэгдэл тооцож олгодоггүй, байгаль хамгаалагчдын ар гэр, хүүхэд ажил хийх, сургуульд явах, шаардлагатай үед эмнэлгийн тусламж авахад бэрхшээлтэй байдаг зэрэг шалтгааны улмаас ихэвчлэн тэтгэврийн насны хүн байгаль хамгаалагчаар ажиллаж байна.

Хамгаалалтын захиргаадын мэргэжилтнүүдийг сургах, давтан сургах сургалтууд зохиогдож байгаа ч тогтмолжуулах, ялангуяа байгаль хамгаалагчдыг байнга сургаж боловсруулж байх шаардлагатайг шалгалтын бүх тайлангуудад дурьджээ.

Ийнхүү байгаль хамгаалагч нарын мэдлэг дутмаг, бие хамгаалах хэрэгсэл, нормын хувцасны хангамж, холбооны хэрэгслийн зай хүрэлцээгүй, холбоо барих болон унааны боломж муугаас хяналт шалгалтаар цөөн явдаг, ажлын хариуцлага алдаж олон дахин солигдсон зэрэг нь хамгаалалтын үйл ажиллагааны үр нөлөөнд муугаар нөлөөлж иржээ.

Хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын хамгаалах хэрэгсэл хангалтгүйг далимдуулан буудаж, сүрдүүлэх, машинаар чирэх, зодох зэрэг үйлдлийг хууль зөрчигчид

Аудитын дүн

цөөнгүй гаргасан байна. Тухайлбал, Өмнөд говийн хамгаалалтын захиргааны дарга, байгаль хамгаалагчдыг алт хууль бусаар олборлогчид зодож, машинаар чирсэн, Богдхан уулын ДЦГ-ын байгаль хамгаалагчийг зодсон, Мянган угалзатын БЦГ-ын улсын байцаагчийг буудаж сүрдүүлжээ.

Аудитын явцад 3 хамгаалалтын захиргааны санхүүгийн үйл ажиллагаанаанд 1,3 сая төгрөгийн төлбөрийн акт тавьж, 3,5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв. (Хавсралт №1)

Дүгнэлт

Байгаль орчны аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, дүн шинжилгээнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. УИХ-аас баталсан “ТХГН-ийн үндэсний хөтөлбөр”-т заасан 2005 гэхэд нийт газар нутгийн 15 хувьд хүргэж сүлжээг өргөтгөх зорилт бүрэн биелэгдсэнгүй.
2. ТХГН-т хулгайгаар ан агнах, ашигт малтмал олборлох, бэлчээр талхлагдах, хууль бусаар мод бэлтгэх, байгалийн баялгийг зүй бус ашиглах, орчныг бохирдуулах зэрэг зөрчлүүд гарсаар байна.
3. БОЯ, АМХЭГ, мэргэжлийн хяналтын байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, аймаг, сумын Засаг дарга нарын хоорондын ажлын уялдаа холбоо муу, хууль зөрчигчидтэй нэгдсэн бодлогоор шийдвэртэй тэмцэж чадахгүй байна.
4. ТХГН-ийн хамгаалалтын захиргааны урьдчилан сэргийлэх, хяналт, шалгалт хийх зардлын төсөв хүрэлцээгүйгээс хариуцсан газар нутгийг бүрэн хамруулж хянах боломжгүй, холбооны техник хэрэгсэл хангалтгүй, байгаль хамгаалагч нар зохих стандартаас 2-3 дахин их талбай хариуцаж байгаагаас хулгайн ан, хууль бус үйлдлийг илрүүлэх боломж муу байна.
5. Хамгаалалтын захиргааны удирдлага өөрийн орлогыг нэмэгдүүлэх талаар санаачлага муутай байна.
6. Тусгай хамгаалалттай бүс нутгийн ургамал, амьтны талаар дорвитой судалгаа, шинжилгээ хийгээгүй, биологийн төрөл зүйлийн хяналт, хамгаалалт хангалтгүй байна.
7. ТХГН-ийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын орон тоог цөөрүүлсэн нь ТХГН-ийн хамгаалалт сулрахад нөлөөлж байна.

Холбогдох байгууллагын санал

Байгаль орчны яамны санал



МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ

210620а Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44,
Засгийн газрын III байр, Утас: 32-32-73, Факс: 32-14-01
E-mail: monenv@mail.mn

2004.12.22 № 6/1955
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний Аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, түүний удирдлагын үр нөлөөнд хийсэн байгаль орчны аудитын тайлантай танилцлаа.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн гаргасан зөвлөмжийн дагуу цаашид тодорхой арга хэмжээ авч ажиллах болно.



0802759

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвлөж байна:

1. ТХГН-ийг хамгаалах, гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх талаар Төрийн захиргааны болон хууль, хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах асуудлыг боловсруулж, хуульд заасан хариуцлагын тогтолцоог мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.
2. Тусгай хамгаалалттай бүс нутгийн биологийн төрөл зүйлийн талаар мэдээллийн нэгдсэн сан байгуулж, хяналт шинжилгээг тогтмолжуулах.
3. ТХГН-ийн хамгаалалтын захиргаадыг мэргэжилтэй боловсон хүчин, шаардлагатай техник хэрэгсэл, материаллаг баазаар хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
4. Ард иргэдэд байгаль экологийн талаар сургалт таниулгыг эрчимтэй зохион байгуулах.
5. Газрын даацыг тооцох аргачлал боловсруулж, нэн тэргүүнд Богдхан уулын ДЦГ-ын Зайсангийн ам, Горхи тэрэлж, Хөвсгөлийн БЦГ-ын жуулчны баазын газрын даацыг тооцох, байгаль орчны үнэлгээний чанарыг сайжруулан, түүнд тавих хяналтыг чангатгах.
6. ТХГН-т газар ашиглаж байгаа бүх аж ахуйн нэгжийн гэрээ, гэрчилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, газрын төлбөр зэрэгт шалгалт хийж, цэгцлэх.
7. Хамгаалалтын захиргаадад орлогоо нэмэгдүүлэх сонирхол, хөшүүрэг бий болгох.

Зөвлөмж

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266
дугаарын факсаар харилцана уу.

Үндэсний аудитын газрын
нэгдүгээр хэлтсийн дарга

Д.ГАНБИЛЭГ